

## Хувийн хэвшлийн Эрүүл мэндийн салбар

Ардчилал, зах зээл Монгол улсад эхэлсэн үеэс дан ганц улсын өмч задарч олон хэвшлийн байгууллага, нэгж үүссэний томоохон хэсэг нь эрүүл мэндийн хувийн хэвшил билээ. 1990 оноос өмнө эмнэлгийн байгууллага гэдэгт улсын хөрөнгө оруулалтаар байгуулагдаж, төсвөөр санхүүждэг, хүмүүст эмнэлгийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг төр улсын байгууллагын ганцхан хэлбэрийг багтаасан ойлгож, хэрэв эмч хүн үзлэг эмчилгээ хийснийхээ төлөө мөнгө төгрөг, эд материал авбал эмчийн ёс зүйд, харш хээл хахуульд тооцож цээрлэдэг хатуу хориотой зүйл байлаа.

Гэвч хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын анхны эх үүсвэр бий болсныг дурдахад : Улаанбаатар хотын АДХГЗ-ны дэргэдэх Иргэдээс хувиараа хөдөлмөр эрхлэх, хөдөлмөрийн хоршоолол байгуулж ажиллуулахад туслах товчооны даргын 1988 оны 10 сарын 29-ний өдрийн 60 дугаар тушаалаар эмнэлэг үйлчилгээний "Прометей" хоршооллыг Анагаах ухааны дэд доктор Н.Цэгмид эзэнтэй байгуулах зөвшөөрлийг өгч ажиллуулж байжээ. 2 жилийн дараа Улаанбаатар хотын АДХГЗ-ны Эрүүлийг хамгаалах газрын зөвлөлийн 1990 оны 02 дугаар сарын хурлаас тус хоршооллыг Эмнэлэг үйлчилгээ явуулах төв болгон баталгаажуулсан.

Ер нь Монгол орон зах зээлд шилжсэн эхний хоёрхон жилд хувийн хэвшлийн эмнэлэг 70 гаруй, эмнэлгийн хоршоо 15, эмнэлгийн пүүс 7, хувийн эмийн сан 30, бүрэн бус хариуцлагатай компани 2, хувийн үйлдвэр 6 байгуулагдан Монгол улсын аж ахуйн нэгжийн тухай хуулийн дагуу улсын бүртгэлд бүртгэгдэн, Эрүүл мэндийн яам, эрхий бүхий байгууллагаар батлагдан баталгаажиж, төлбөртэйг ээр үйлчилж байв.

Анхдагч заримыг нь дурдвал : эрүүлийг хамгаалахын ахмад зохион байгуулагч,нийгмийн эрүүл мэндийн томоохон төлөөлөгч Базар Амгаабазар гуай санаачилж, гол төлөв тэтгэвэрт байгаа нарийн мэргэжлийн эмч нарыг зохион байгуулж "Алтан хундага" эмнэлгийн байгуулан, уламжлалт болон орчин үеийн эмчилгээ заслыг хийж байлаа.

Мөн Монгол улсад уламжлалт анагаах ухааны чиглэлээр хувийн хэвшлийн анхдагч нь "Манба дацан" болно.

Монгол оронд 60 гаруй жил тасарсан уламжлалт анагаах ухааны эм эмчилгээн, сургалт, өв уламжлалыг дахин шинээр сэргээн хөгжүүлэх зорилгоор 1990 онд Уламжлалт эмнэлэг сургалтын төв "Манбадацан тэргүүн хамба лам, оточ, гэвш, гавьяат эмч Д.Нацагдорж санаачлан үүсгэн байгуулсан.

Улаанбаатар хотын АДХГЗ-ны 1990 оны 272 дугаар тогтоолоор батлагдсан "Хувийн үйлдвэр , пүүс байгуулахад эрх олгох, бүртгэх журам"-ын дагуу Х.Долгормаа эзэнтэй уламжлалт эмчилгээний "Биндэрьяа" анхны эмнэлгийн хоршоо мөн манай улсад хавдрыг мэс заслаар эмчлэх мэргэжлээрээ алдаршсан гавьяат ахмад эмч П.Сагараажав Дархан хотод "Оточ нэртэйгээр байгуулж уламжлалт, эмчилгээ, зүү төөнүүр заслыг голчилсон чиглэлээр үр бүтээлтэй ажиллаж байв.

Энэчлэн анхны бүрэн бус хариуцлагатай компанийг эм зүйч Л.Хүрэлбаатар "Монос" нэртэйгээр санаачлан хөгжүүлж, эм гоо сайхны зүйл үйлдвэрлэх: анхны хувийн эмийн санг С.Рина "Мөнгөн дэнс" нэртэйгээр байгуулж, монгол,европ эмээр үйлчлэх, анхны эм,шүдний хувийн үйлдвэрийг Г.Очирваань"Сувд" П.Нямдорж "Уламжлалт эмнэлэг"

нэртэйгээр үндэслэж эмнэлэг үйлчлүүлэгчдийг хууль журмын дагуу явуулж байлаа. манай эмч нар зарим пүүс, хоршоотой хоршиж гадаадаас нарийн мэдрэмж бүхий багаж төхөөрөмж авчирч, барилга байшин түрээслэн авч хувийн эмнэлэг нээж байлаа. Эрүүл мэндийн яамны олон хэв шинжит үйлчилгээг зохих хууль журмын дагуу эрхлэн явуулахыг дэмжиж 1990 онд 185, 1991 онд 162,163, 174, 1992 онд 25,26,1993 онд 85 дугаар тушаалуудыг гаргаж мөрдүүлсэн байна.

1991-1992 оны байдлаар нийслэл хотод нийтдээ 118 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн эрх авч, улсын бүртгэлд бүртгэгдсэн боловч 3 удаагийн шалгалтаас үзэхэд 34 үйл ажиллагаа явуулж жигдэрсэн байна.

МУЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эрүүл мэндийн сайдын А/141 дүгээр тушаалыг биелүүлэх зорилгоор нийслэлийн эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллага, хүмүүст эмнэлэг үйлчилгээний ажил эрхлэх зөвшөөрөл олгох мэргэжлийн комиссыг Нийслэлийн Засаг даргын 1993 оны 11 сарын 08-ны өдрийн а/237 дугаар захирамжаар шинэчлэн ЭМГ-ын даргаар ахлуулсан 16 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байлаа.

1993 оны 3,4 дүгээр сард МУ-ын ЭМЯ, Нийслэлийн ЭМГ-аас нийслэлийн эрүүл мэндийн хувийн хэвшлийн 142 байгууллагын эмнэлэг үйлчилгээтэй танилцан шалгалт хийхэд: тухайн үедээ ажиллаагүй 34, хаяг нь тодорхойгүй, олдоогүй 36, гадаад ажиллахаар явсан 8, нийт 78 хувийн эмнэлэг шалгалтад хамрагдаагүй байна.

1995-1996 онуудад "Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын тухай" Эрүүл мэндийн сайдын 1994 оны 125 дугаар тушаал гаргуулан мөрдөж ажилласан байна.

1991 оны сүүлийн 2 сард 6 эмнэлэг, эмийн сан, 1992 онд 53, 1993 онд 52, 1994 онд 40, 1995 онд 62, 1996 онд 43, 1997 онд 237, 1998 онд 142, 1999 онд 130, 2000 оны эхний байдлаар 70 гаруй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байв. 2000 онд нийслэлд 697 хувийн хэвшлийн байгууллага байв. Эдгээрийн 347 нь хувийн хэвшлийн эмнэлэг, үүний 86 шүдний 36 нь уламжлалт эмчилгээний 47 нь эмэгтэйчүүдийн 178 нь бусад мэргэжлийн чиглэлийн эмнэлэг байлаа. 350 эмийн сангийн эм, хангамжийн бусад байгууллага байлаа.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нь Монгол оронд өрнөсөн ардчиллын, зах зээлийн нийгмийн үр дагавар болж гарч ирсэн билээ. Гэхдээ Монгол оронд анхны эмпирик аяндаа үүссэн анагаах ёсон нь хувийн, өрх гэрийн байсан.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн түүх одоогоор харьцангуй богинохон учраас томоохон үе шатлалд хуваан тогтоох боломжгүй бөгөөд нөгөө талаар улс орон маань нийгмийн нэг тогтолцооноос нөгөөд шилжээд удаагүй зах зээлийн эдийн засгийн эхэн /шилжилтийн үе/ төлөвших, эрчимжих үе явагдаж байгаа билээ. Гэхдээ хэдий ч богино хугацаанд үйл явдлын хэмжээ цар хүрээ, хөгжил дэвшил, онцлогийг харгалзан үе шатлалд хувааж болдог учир хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн түүхийг:

1. Ардчилсан зах зээлийн нийгмийн шилжилтийн эхэн үеийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага /1990-1995/

2. Ардчилсан зах зээлийн нийгмийн төлөвшилтийн үеийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага /1995-2000/

3. Зах зээлийн эрчимжигчийн үеийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд /2001-2010/

Энэ нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн үе шатлал, байдалтай холбогдуулан тоймлон үзсэн хэрэг. Тэгвэл хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын дотоод үйл ажиллагаа, хөгжилтэй нь холбон үечилбэл

1. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үндэс,суурь тавигдаж эхэлсэн үе /1990-1996/

2. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн эхний үе /1996-2000/

3. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага өргөжин тэлж эхэлсэн үе /2000 ноос хойш үе/ хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага тоо, хүчин чадал, үйлчилгээний чанарын хувьд хурдацтай хөгжиж эхэллээ.

2002 оноос аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль гарч хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тоот 12,7 дахин өсч 1067 хүрсэн байна.

Эм хангамжийн байгууллагын хувьд 2000-2008 онд тодорхой ажил хийгдсэний дотор: 2001 онд Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 169 дүгээр тушаалаар эмийн сангийн талаар мөрдөх дүрэм журмыг баталсан.

1 зэрэглэлийн эмийн сан 53, 2 зэргийн эмийн сан 168, эмийн сангийн салбар 127, бүгд 348 нэгж эмийн сан, салбар ажиллаж байв. Үүнд : 836 хүн ажиллаж байгаагийн 241 эм зүйч 394 эм найруулагч,201 бусад мэргэжлийн хүн байжээ.

19 эмийн үйлдвэр,55 эм ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаагаа явуулж эдгээрт 967 хүн ажиллаж байсны 230 эм зүйч, 269 эм найруулагч 468 бусад мэргэжлийн хүн байв.

Нийслэл хотод нийт 422 эм хангамжийн байгууллага байсны 36 нь/8,5%/ төрийн өмчийн, 386 /91,6%/ хувийн хэвшлийн өмчлөлтэй байгууллага байв.

Хувийн хэвшлийн байгууллагуудын ангилал:Эрүү мэндийн байгууллагуудыг ангилахдаа нэршил, үйлчлэх хүрээ, мэргэжлийн чиглэл, үйл ажиллагааны хүрээ, өмчийн хэлбэр зэрэг олон янзаар ангилдаг

1.Амбулаторийн тусламж үйлчилгээ

2. Хэвтэн эмчлэх тусламж үйлчилгээ

3. Пара клиникийн /лаборатори,рентген,ЭХО,Дурангийн зэрэг оношлог ооны чиглэлээр ажилладаг

Эм хангамжийн байгууллагуудыг

1. Эмийн сан түүний салбар
2. Эмийн бөөний худалдааны
3. Эмийн үйлдвэрлэл, эмнэлгийн техникийн
4. Уламжлалт эмийн

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагуудыг

1. Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны
2. Ариутгал халдваргүйтэлийн
3. Гоо заслын үйлчилгээний гэх мэт ангилдаг.